

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
2. Үйлчилгээний албан хаагчдад ур чадварын үнэлгээ хийгээгүй, ур чадварын нэмэгдэл олгоогүй.	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

85129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ К.САЛТАНАТ ТАНАА

2023.02.24 № 163
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сургууль нь шинээр 2 кабинет байгуулсан ба дотуур байрны хүүхдийн дунд хүүхэд хөгжүүлэх төвтэй болсон байна.

Аудитын гол асуудал

Хүнсний материалын тооцоо, тооллого, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>112,346,096.94</u>	<u>137,374,775.59</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	34,069,147.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	34,069,147.00
3121	Төгрөг	-	34,069,147.00
31211	Төрийн сангийн харилцах	-	34,069,147.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	112,346,096.94	103,305,628.59
354	Хангамжийн материал	112,346,096.94	103,305,628.59
35410	Бичиг хэргийн материал	-	200,000.00
35420	Аж ахуйн материал	51,495,225.00	52,780,515.00
35440	Түлш, шатах тослох материал	369,022.35	-
35460	Хүнсний материал	30,041,197.59	19,884,461.59
35470	Бусад хангамжийн материал	30,440,652.00	30,440,652.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,772,461,541.44</u>	<u>2,988,743,359.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,772,461,541.44	2,988,743,359.73
392	Биет хөрөнгө	2,749,051,541.44	2,965,333,359.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,038,857,864.48	3,298,553,116.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(463,322,609.42)	(557,445,119.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68,213,500.00	118,213,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,463,499.96)	(32,796,833.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,217,854.00	82,918,662.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(99,788,902.18)	(29,664,529.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,399,202.00	117,471,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,457,676.63)	(67,359,469.91)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39217	Нөм	29,395,809.15	35,442,533.79
393	Биет бус хөрөнгө	23,410,000.00	23,410,000.00

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	23,410,000.00	23,410,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,884,807,638.38</u>	<u>3,126,118,135.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,199,000.00</u>	<u>1,170,498.61</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,199,000.00	1,170,498.61
413	Өглөг	11,199,000.00	1,170,498.61
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,170,498.61
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	11,199,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	11,199,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,873,608,638.38</u>	<u>3,124,947,636.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,873,608,638.38	3,124,947,636.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	299,861,904.00	299,861,904.00
51101	Өмч: - төрийн	299,861,904.00	299,861,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,155,591,954.76	2,426,471,040.35
51210	Өмнөх үеийн үр дүн	2,155,591,954.76	2,175,132,042.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	251,338,998.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	418,154,779.62	398,614,692.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,884,807,638.38</u>	<u>3,126,118,135.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,279,467,604.40	1,924,737,424.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	345,594.00	2,385,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	345,594.00	2,385,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	345,594.00	2,385,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	345,594.00	2,385,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,279,122,010.40	1,922,352,424.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,225,659,812.40	1,736,995,424.64
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,194,522,200.00	1,403,278,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	31,137,612.40	333,716,724.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,937,198.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,937,198.00	-

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,525,000.00	185,357,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,525,000.00	185,357,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,599,111,109.94	1,673,398,426.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,599,111,109.94	1,673,398,426.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,571,109,655.64	1,616,646,537.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	969,909,340.70	1,113,686,838.61
210101	Үндсэн цалин	853,637,223.70	896,812,838.61
210102	Нэмэгдэл	-	187,865,300.00
210104	Урамшуулал	52,847,743.00	29,008,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	63,424,374.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,887,174.00	130,477,000.00
210201	Тэтгэврийн даатгал	89,421,574.00	87,422,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,116,300.00	10,763,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,293,000.00	8,610,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,823,600.00	2,152,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,232,700.00	21,527,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,524,700.00	59,859,200.75
210301	Гэрэл, цахилгаан	3,382,700.00	7,360,600.00
210302	Түлш, халаалт	47,142,000.00	52,216,000.75
210303	Цэвэр, бохир ус	-	282,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,526,205.40	22,381,361.60
210401	Бичиг хэрэг	1,644,298.00	1,361,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,521,118.40	4,439,751.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,354,000.00	-
210404	Ном, хэвлэл	-	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,006,789.00	16,535,410.00
2105	Нормативт зардал	79,176,970.50	132,750,401.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	242,000.00	544,080.00
210502	Хоол, хүнс	78,934,970.50	132,206,321.00
2107	Томилолт, зочны зардал	154,200.00	400,000.00
210702	Дотоод албан томилолт	154,200.00	400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	954,450.00	5,711,029.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,450.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,711,029.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,976,615.04	151,380,706.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,741,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,562,319.00	6,522,640.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	327,414,296.04	134,116,906.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,001,454.30	56,751,889.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,617,142.00	56,745,700.00

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,617,142.00	56,745,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,384,312.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,384,312.30	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,189.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,189.00
213404	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(319,643,505.54)	251,338,998.33
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225003	Хөрөнгө оруулалтын гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(319,643,505.54)	251,338,998.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,247,984,398.00	1,588,635,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,247,984,398.00	1,588,635,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,194,522,200.00	1,403,278,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,194,522,200.00	1,403,278,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,937,198.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,937,198.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,525,000.00	185,357,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,525,000.00	185,357,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,236,639,548.00	1,537,884,553.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,236,639,548.00	1,537,884,553.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,200,935,035.70	1,480,992,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	958,311,363.70	1,112,516,438.00

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	842,039,246.70	883,589,774.00
210102	Нэмэгдэл		199,891,124.00
210104	Урамшуулал	52,847,743.00	29,035,540.00
210105	Гэрээт ажлын хөлс	63,424,374.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,887,174.00	130,476,902.00
210201	Тэтгэврийн даатгал	89,421,574.00	87,422,402.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,116,300.00	10,763,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,293,000.00	8,610,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,823,600.00	2,152,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,232,700.00	21,527,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,775,000.00	72,036,600.00
210301	Гэрэл, цахилгаан	5,620,000.00	7,686,600.00
210302	Түлш, халаалт	41,155,000.00	63,350,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,701,798.00	-
210401	Бичиг хэрэг	599,398.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,023,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,354,000.00	-
210404	Ном, хэвлэл	405,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,920,400.00	-
2105	Нормативт зардал	43,775,810.00	122,032,295.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	983,800.00	-
210502	Хоол, хүнс	39,717,110.00	122,032,295.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,074,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	750,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	412,740.00	-
210702	Дотоод албан томилолт	412,740.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,753,400.00	7,787,979.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,253,400.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		7,787,979.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,567,750.00	35,342,186.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	24,068,296.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,267,750.00	11,273,890.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,704,512.30	56,892,153.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,320,200.00	56,885,964.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,320,200.00	56,885,964.00

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,384,312.30	6,189.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,384,312.30	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,189.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>11,344,850.00</u>	<u>50,751,147.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,344,850.00	16,682,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,344,850.00	16,682,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,344,850.00	16,682,000.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,344,850.00	16,682,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,344,850.00)</u>	<u>(16,682,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	34,069,147.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		34,069,147.00

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	299,861,904.00	479,742,690.62	1,407,581,244.46	2,187,185,839.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			4,384,611.00	4,384,611.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,861,904.00	479,742,690.62	1,411,965,855.46	2,191,570,450.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-61,587,911.00	-95,334,366.73	-156,922,277.73
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайланг үеийн үр дүн			838,960,466.03	838,960,466.03
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	418,154,779.62	2,155,591,954.76	2,873,608,638.38
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	418,154,779.62	2,155,591,954.76	2,873,608,638.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			19,540,087.26	19,540,087.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,861,904.00	418,154,779.62	2,175,132,042.02	2,893,148,725.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-19,540,087.26		-19,540,087.26
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайланг үеийн үр дүн			251,338,998.33	251,338,998.33
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	398,614,692.36	2,426,471,040.35	3,124,947,636.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,588,635,700.00	1,554,560,364.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,588,635,700.00	1,554,560,364.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,528,011,700.00	1,497,674,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,112,617,000.00	1,112,516,438.00
210101	Үндсэн цалин	895,743,000.00	883,589,774.00
210102	Нэмэгдэл	187,865,300.00	199,891,124.00
210104	Урамшуулал	29,008,700.00	29,035,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,477,000.00	130,476,902.00
210201	Тэтгэврийн даатгал	87,422,500.00	87,422,402.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,763,700.00	10,763,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,610,900.00	8,610,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,152,800.00	2,152,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,527,100.00	21,527,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,042,600.00	72,036,600.00
210301	Гэрэл, цахилгаан	7,682,600.00	7,686,600.00
210302	Түлш, халаалт	63,360,000.00	63,350,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	148,793,600.00	122,032,295.00
210502	Хоол, хүнс	148,793,600.00	122,032,295.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,790,600.00	7,787,979.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,790,600.00	7,787,979.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,490,900.00	52,024,186.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,805,000.00	40,750,296.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,685,900.00	11,273,890.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,624,000.00	56,885,964.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,624,000.00	56,885,964.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,624,000.00	56,885,964.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,588,635,700.00	1,588,629,511.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,403,278,700.00	1,403,278,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,403,278,700.00	1,403,278,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,357,000.00	185,350,811.00
132001	Орон нутгийн төсвөөс	185,357,000.00	185,350,811.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		34,069,147.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	99	99
620001	Удирдах ажилтан	4	4
620002	Гүйцэтгэх ажилтан	44	44
620003	Үйлчлэх ажилтан	39	39
620004	Гэрээт ажилтан	12	12
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	99	99
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	48	48
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	39	39
650010	Гэрээт ажилтан	12	12

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,937,198.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,937,198.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,937,198.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	637,198.00	-
210401	Бичиг хэрэг	237,198.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,937,198.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,937,198.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,937,198.00	-
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн, сурлагын хоцрогдлыг арилгах” зорилго дэвшүүлэн ажилласан байна..

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед малчин айлын хүүхдүүдэд сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг бүрдүүлэх, цахим хичээлээр хичээл заах боломж бүрдүүлэх, харилцах дэвтэр болон бие даан ажиллах даалгаврын сантай болох
- Багш бүр хоцрогдлыг арилгах талаар тусгай төлөвлөгөө гаргаж, суралцагчдын сургалтын чанарт ахиц гаргах
- Чадвартай багшийг сонгон шалгаруулах шалгаруулалтыг ил тод шударгаар зохион байгуулах зорилго, зорилтыг мөрдлөг болгох

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварын явц, үр дүнд тогтмол шинжилгээ хийж хоцрогдлыг арилгах сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлж ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2020 онд хэвлэгдэн гарсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна..

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 241.3 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		34,069.1	34,069.15
Авлага			-
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	112,346.1	103,305.6	(9,040.47)
Үндсэн хөрөнгө	2,772,461.5	2,988,743.4	216,281.82
Нийт хөрөнгө	2,884,807.6	3,126,118.1	241,310.5
Өр төлбөр	11,199.0	1,170.5	(10,028.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,873,608.6	3,124,947.6	251,339.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,884,807.6	3,126,118.1	241,310.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 34.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалин, НДШ, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний зардал, үдийн цайны зардлуудыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна. Дээрх зардлуудаас хоол, үдийн цайны зардлын хэмнэлт 30.5 сая төгрөг байна.

Авлага, урьдчилж гарсан зардал данс оны эхэн, эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын данс 9.0 сая төгрөгөөр буурсан нь хоол хүнс болон түлш шатах тослох материалын үлдэгдэл буурсан холбоотой, аж ахуйн материалын үлдэгдэл 1.3 сая төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант онд 2.4 сая төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Сумын ИТХ-ын хуралдааны 50 дугаар тогтоолоор 2.5 сая төгрөгийн ашиглах боломжгүй бараа материалыг акталж, устгасан байна.

Үндсэн хөрөнгийн данс 216.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 16.7 сая, үнэ төлбөргүй 333.7 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 134.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын хуралдааны 104 дугаар тогтоолоор элэгдлээ бүрэн нөхсөн 103.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасаж, сургуулийн захирлын тушаалаар устгалын комисс байгуулж, акталж устгасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.2 сая төгрөг болж 10.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны 11.2 сая төгрөгийн түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг өглөгийг барагдуулж, шинээр оны эцэст 1.2 сая төгрөгийн НДШ-ийн өглөгтэй гарсан байна. Өглөг үүссэн шалтгаан нь оны эхний 1-4 сарын ТҮ-гийн ажилчдын цалингийн дутуу ирүүлсэнтэй холбоотой НДШ өглөгтэй гарсан байна.

Тайлант онд 251.3 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 251.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,982.9 сая, орон нутгийн төсвөөс 183.1 сая, нийт зарлагыг 2,166.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 577.4 сая төгрөгөөр бууруулж 1,588.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,413.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 185.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 1423.3 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,403.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 185.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, улсыг төсвөөс 10.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,554.6 сая төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь хоол, үдийн цай, бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80112-Нийтлэг үйлчилгээ	185,357.00	185,350.80	-6.2	100.0
2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	3,116.30	2,955.20	-161.1	94.8
3	80312-Сургалт семинар	1,558.10	1,558.10	0.00	100.0
4	80823-Эрүүл мэндийн арга хэмжээ	3,583.70	3,500.00	-83.7	97.7
5	81801-Үдийн цай	60,624.00	56,885.96	-3,738.0	93.8
6	81806-Дотуур байрны үйлчилгээ	231,021.00	204,179.50	-26,841.5	88.4
7	81816-Хүүхдэд ээлтэй орчин	16,485.00	16,182.00	-303.0	98.2
8	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	7,011.60	4,732.45	-2,279.2	67.5
9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	779,063.50	778,400.80	-662.7	99.9
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	300,815.50	300,815.50	0.00	100.0
	Дүн	1,588,635.70	1,554,560.32	-34,075.4	97.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,599.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 24.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,673.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 25.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 74.3 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 0.1 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.006 сая, нормативт зардлыг 26.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.003 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 3.5 сая, үдийн хоолны зардлыг 3.7 сая, нийт 34.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа зөрчил гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2022 онд нийт 1,454.9 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүрэн мэдээлсэн хэрэгжилтийн хувь 100% байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар сургууль нь оны эцэст үүссэн 11.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан.

Мөн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл бүрэн байршуулаагүй, тайлан онд 6.1 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж

тайлагнасан, сургууль нь жилийн эцэст хүнсний материалын дансанд 30.0 сая төгрөгийн үлдэгдэл их хэмжээгээр нөөцөлсөн зэрэг зөрчлийг арилгах талаар 3 заалттай зөвлөмж өгсөн.

Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад 100.0%-ийн биелэлттэй байна.

Хүснэгт: 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	13,499.0	1	13,499.0	100%
Зөвлөмж	3	6,100.0	3	6,100.0	100%
Нийт дүн	4	19,599.0	4	19,599.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар сургуулийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн зөрчил илэрч акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчлийн дүнгээр төлбөрийн акт тогтоосон.Үүнд:

1. Сургуулийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар 01-ны өдрийн А/35, А/10/9 дүгээр хамтарсан тушаалыг баримтлалгүйгээр аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/182 тоот захирамжаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны хүчингүй болсон 362/112/183 дугаар хамтарсан тушаалыг үндэслэж 2022 оны 1-6 дугаар сар хүртэл 1.5 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хууль бусаар авсан байна.

2. Тайлант оны 12 сард ажил хавсран гүйцэтгэсэн мэдээлэл зүйн багшийн илүү цагийн хөлс 0.2 сая төгрөгийг давхардуулан олгосон.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сургуулийн захирал нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт" -ийг зөрчиж ур чадварын нэмэгдэл авсан байна.	1	1,555.1			1	1,555.1						
Тайлант оны 12 сард ажил хавсран гүйцэтгэсэн мэдээлэл зүйн багшийн илүү цагийн хөлсийг давхардуулан олгосон.	1	161.5			1	161.5						
Дүн	2	1,716.6			2	1,716.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит